

ОЙ ХЭЭРИЙН БОЛОН ОБЪЕКТЫН ГАЛ ТҮЙМРИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

*ДХИС-ийн “Ахлагч” Мэргэжлийн боловсролын сургуулийн
Онцгой байдлын албаны тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа Г.Ганхөлөг
E-mail: g.gankhulug427@gmail.com*

Хураангуй

Монгол улс болон бүс нутгийн хэмжээнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах үйл ажиллагааг бий болгох оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлох шаардлага өнөөгийн нөхцөл байдал харуулж байна.

Мөн объектын түймрийн нөхцөл байдал Монгол Улсын хэмжээнд хоногт 10-30 удаагийн дуудлага мэдээлэл бүртгэгдэж байна. Сүүлийн 2 жилийн статистик тоон мэдээллээс үзэхэд Гал түймрийн эрсдэлийг бууруулах, иргэн аж ахуйн нэгж байгууллагын ажилтан алба хаагчийг гал унтраах дадлага сургуулийг тогтмол зохион байгуулах шаардлага тулгарч байна.

Түлхүүр үг: Ой хээрийн түймэр, объектын гал түймэр, аюулгүй байдал.

Оршил

Ой, хээрийн түймэр болон объектын гал түймэр нь хүн төрөлхтөнд эдийн засаг, нийгэм, байгаль орчны хувьд ихээхэн хохирол учруулдаг ноцтой асуудал юм. Энэхүү илтгэлээр бид эдгээр хоёр төрлийн гал түймрийн нийтлэг болон өөр өөр шинж чанар, тэдгээрийн үүсэх шалтгаан, тархах хурд, үр дагавар болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар авч үзэх бөгөөд Монгол Улсын хувьд дээрх 2 төрлийн гал түймрийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй харуулахыг хичээх болно.

Үндсэн хэсэг

ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМЭР

Ой, хээрийн түймэр гэдэг нь ой, хээрийн бүсэд байгалийн болон хүний үйл ажиллагааны үүдэн шатамхай ургамал хөрсөөр дамжин гал хяналтгүй тархах үзэгдэл юм. Ойн түймэр нь байгалийн үзэгдэл болох аянга цахилгаанаас гарах, хүний хайхрамжгүй байдлаас үүдэн гардаг жишээлбэл: Ил задгай гал түлэх, тамхины иш хаях, санаатайгаар түймэр тавих, мод бэлтгэх

үйлдвэрлэлийн технологийн зэрэг үзэгдлээс шалтгаалж байна.

Монгол Улс нь 4 бүсэд хуваагддаг бөгөөд ихэвчлэн хангайн бүс буюу хойд бүс, тал хээрийн бүс буюу зүүн бүсэд ой, хээрийн түймэр гардаг. Тохиолдож байсан томоохон хэмжээний ой хээрийн түймрээс дурьдвал завхан аймагт 1996 онд тохиолдсон ойн түймэрт 120 гаруй хоног 280 гаруй алба хаагч, 2017 оны зүүн 3 аймгийг хамарсан хээрийн түймэрт 30 гаруй хоног 250 гаруй алба хаагч тус тус үүрэг гүйцэтгэж байсан түүхтэй.

1970-2000 оны хооронд түймрийн эргүүлийн нислэг хийж байсан бөгөөд тухайн үед АН-2 загварын далавчит онгоцоор 10 хүний бүрэлдэхүүнтэй шүхэрчин гал сөнөөгчид нислэг үйлдэж түймрийг агаараас илрүүлэн богино хугацаанд унтрааж байсан сайн туршлагатай байжээ. Мөн ой бүсэд ойн цэвэрлэгээг жил болгон хийж байсан нь түймэр гарах эрсдэлийг бууруулж байсан байна.

Өнөөдрийн нөхцөлд хуурай сэрүүн цаг агаартай манай орны хувьд ой, хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд түргэн шуурхай унтраах хуучны дадлага туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай байгаа юм.

Ялангуяа ой, хээрийн түймрийг хиймэл дагуулын тусламжтай болон нислэг үйлдэж буй агаарын тээврийн компаниудтай нягт хамтран ажиллах шаардлага нөхцөл тулгарч байна. Их хэмжээний түймэр гарсан тохиолдолд мргэжлийн аврагч-гал сөнөөгчдийг тухайн түймэр гарсан орон нутагт тээвэрлэн хүргэхэд хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Мөн ой, хээрийн түймэр унтраах орчин үеийн техник тоног төхөөрөмжүүдийг түймэр унтраах үйл ажиллагаанд түлхүү ашиглах хэрэгцээ шаардлага үүсч байна.

Монгол Улсын сүүлийн 2 жилийн хугацаанд ой, хээрийн түймэр 2022 онд 181 тохиолдол 922,423 га талбай 2023 онд 101 тохиолдол 543,986 га талбай өртөж унтраах үйл ажиллагаанд давхардсан тоогоор Онцгой байдлын байгууллагын аврагч, гал сөнөөгчид мэргэжлийн ангийн болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сайн дурын бүлэгүүд нийт 11,589 албан хаагч ажилласан байна.

Дээрхээс үзэхэд ой хээрийн түймэр нь дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мөн хүний буруутай үйл ажиллагаа зэргээс гарч байгаа бөгөөд урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, иргэн аж ахуй нэгж байгууллагыг дадлагуулах ажлыг тус тус хийвэл зохистой.

Ой хээрийн түймэр гарах нөхцөл

Уур амьсгалын өөрчлөлт: Дэлхийн дулаарал, хуурайшилт, экологийн тэнцвэрт байдал алдагдах, хүрээлэн буй орчны өөрчлөлт нь ой хээрийн түймэр гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хүний буруутай үйл ажиллагаа: ил задгай гал түлэх, галтай болгоомгүй харьцах, шинэ газар тариалангийн талбай бэлтгэх, ой модонд аялал зугаалга хийх, мод бэлтгэх зэрэг хүний үйл ажиллагаатай шууд холбоотойгоор түймэр гарах гол шалтгаан болдог.

Байгалийн хүчин зүйлс: цаг уурын аюулт үзэгдэл болох ган, аянга цахилгаан, дэлхийн дулаарал зэрэгээс үүдэлтэй байна.

ОБЪЕКТЫН ТҮЙМЭР

Гал түймэр бол хором мөч бүхнээр хэмжигдэх хүний амьдралд маш их болон үлэмж хэмжээний хохирол учруулдаг гамшигт үзэгдэл юм. Монгол Улсын хэмжээнд гал түймрийн тохиолдол бүрийн нэг нь хүүхдийн санамсаргүй үйлдлээс шалтгаалж байна. Монгол Улсад объектын гал түймэр гарах шалтгаан нөхцөл нь санамсаргүй байдлаас 47 хувь, хүүхдийн болгоомжгүй үйлдлээс үйдсэн 9 хувь, эрчим хүч ашиглалтын дүрэм зөрчсөн 21 хувь, бусад эрсдэлээс үйдсэн 23 хувийг тус тус эзэлж байна. Монгол Улсын хэмжээнд объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг тухай явагддагч иргэдийн хайхрамжгүй үйлдлээс шалтгаалж гал түймэрт өртөж байгаа нь харамсалтай.

Гал түймрийн эрсдэлийг буруулахын тулд нэн тэргүүнд шаардлагатай арга хэмжээ бол мэдээж урьдчилан сэргийлэх явдал бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээр объектын гал түймрээс сэргийлж чадна. Үүнд:

1. Гал түймэр гарах аюултай эд зүйлсийг тодорхойлох аюулгүй байдлыг хангах материал тус бүрийн зай хэмжээг стандартын дагуу байлгах.
2. Унтлагын өрөөнд болон бусад өрөө тасалгаанд ил гал гаргах, тамхи татах, цахилгаан хэрэгслийг ямагт салгаж байх.
3. Бага насны хүүхдэд шүдэнз, асаагуур, гал гаргах хэрэгсэл тоглоом биш гэдгийг сайтар сануулж ойлгуулах, гар хүрэх газраас хол тавих.
4. Галын дохиололын системн хэрэглээг айл өрх аж ахуйн нэгж байгууллага бүх нэвтрүүлэх, түүний хэвийн ажиллагааг тогтмол эрх бүхий байгууллагын албан хаагчаар шалгуулж байх

5. Гал түймрийн аюулгүйн гарч ямагт чөлөөтэй байлгах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гал түймэр гарах эрсдэл буурч чадна.

Галын аюулгүй байдлын хангах техникийн шаардлагуудыг иргэн аж ахуй нэгжид дараах байдлаар зохицуулахад гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлж чадна. Үүнд:

1. Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын шаардлагыг хангасан зураг төслийн дагуу угсрах, барилгын хийц бүтээцийг зөвшөөлгүй өөрчлөх;

2. Аврах зам гарцыг чөлөөтэй байлгах, барилгын норм ба дүрмийн дагуу тэмдэг тэмдэглэгээг байршуулах, аврах зам гарцын схем зургийг мэргэжлийн байгууллагаар хянан баталгаажуулах;

3. Цахилгаан тоног төхөөржмийн аюулгүй найдвартай байдлыг хангуулах, технологийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

4. Галын автомат дохион доллын систем суурьлуулах, гал түймрийн үед ажиллах төлөвлөгөөг батлуулж мөрдлөг болгон ажиллах;

5. Барилга байгууламжийн дотуур усан хангамжийн найдвартай ажиллагаа, бэлэн байдлыг хангуулах;

6. Гал унтраах анхан шатны хэрэгслийг стандартын дагуу иж бүрдлийг байршуулах;

7. Гал унтраах дасгал сургуулилтыг тогтмол зохион байгуулах зэрэг арга хэмжээг авч ажиллах нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ болно.

Бас нэг томоохон хүчин зүйл, шалтгаан нөхцөл нь Улаанбаатар хотын хувьд байшин барилга ихээр баригдаж байгаа нь гал унтраах мэргэжлийн байгууллага тухай гал түймэр дээр хүрэлцэн очиход хүндрэлтэй нөхцөл байдал үүсч байгаа. Энэ нь зам гарцын чөлөөтэй бус байдал, барилга орон сууц хотхонуудын хаягжилт бүрэн хийгдээгүй, автмашины зогсоол дутмаг байгаа нь гал түймэр дэлгэрэх гол хүчин зүйл болоод байна.



Гадны улс орнуудын сайн туршлага бол галын аюулгүй байдлын стандартыг бүх нийтээр дагаж мөрдөж байгаа нь эрдэлээс урьдчилан сэргийлэх давуу тал болж байдаг. Үүнтэй зэрэгцээд гал аюулгүй нор, дүрэм, стандартыг хэрэгжүүлээгүй биелүүлээгүй иргэн аж ахуйн нэгж байгууллагад оногдуулах шийтгэл, хариуцлага тооцох торгууль бусад эрх зүйн хэмжээ нь өндөр байдагтай холбоотой.

Манай орны хувьд ч дээрхэд өгүүлж буй нөхцөл байдлыг авч

хэрэгжүүлдэгч эрх зүйн асуудлын хувьд хэт иргэнээ бодсон санкцууд байгаа нь гал аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг боловсрол дутагдаж байгаа нь харагдаж байна.

Объектын гал түймэр зөвхөн 2024 оны нэгдүгээр сард 262 удаа бүртгэгдсэн байна. Статистик тоон баримтыг харвал 2 цаг тутамд объектын гал түймэр гарч 7 хоногт 1 хүн амь насаа алдаж байгаа хамралтай дүн мэдээ гарч байна.

Монгол Улсад сүүлийн 2 жилийн байдлаар статистик тоон үзүүлэлтээс хархад 2022 онд 3075, 2023 онд 3053 удаагийн гал түймэр бүртгэгдэж өдөр тутам улсын хэмжээнд дунджаар 10-30 удаагийн тохиолдол бүртгэгдэж



байна. МУ-ын нийт газар нутгийн ой хээрийн түймрийн эрсдэл (хуурайшилтын индексээр) (WGS84 Өргөрөг, Уртраг: 41.1952, 121.6187 UTM48 Өргөрөг, Уртраг: 1895926.9971, 4695800.0999)

Эх сурвалж

*МУ-ын нийт газар нутгийн ой хээрийн түймрийн эрсдэл
(хуурайшилтын индексээр)*

<i>№</i>	<i>Аймаг</i>	<i>Сум</i>	<i>Эрсдэлийн зэрэг</i>	<i>Хуурайшилтын индекс</i>
1	Дорнод	Хэрлэн	Аюултай зэрэг	3259
2	Дорнод	Халх	Аюултай зэрэг	3238
3	Сүхбаатар	Баруун-Урт	Аюултай зэрэг	3148
4	Сэлэнгэ	Орхон	Аюултай зэрэг	2941
5	Увс	Улаангом	Аюултай зэрэг	2723
6	Хэнтий	Баянхутаг	Аюултай зэрэг	2508
7	Завхан	Алдархаан	Аюултай зэрэг	1945
8	Увс	Баруунтуруун	Аюултай зэрэг	1896
9	Төв	Эрдэнэ	Аюултай зэрэг	1869
10	Сэлэнгэ	Цагаануур	Аюултай зэрэг	1834
11	Сэлэнгэ	Сайхан	Аюултай зэрэг	1713
12	Сэлэнгэ	Сүхбаатар	Дунд зэрэг	1704
13	Төв	Жаргалант	Аюултай зэрэг	1662
14	Булган	Бугат	Аюултай зэрэг	1516
15	Увс	Малчин	Аюултай зэрэг	1501
16	Сэлэнгэ	Орхонтуул	Дунд зэрэг	1178
17	Төв	Угтаалцайдам	Дунд зэрэг	1043
18	Орхон	Баян-Өндөр	Дунд зэрэг	879
19	Сэлэнгэ	Баянгол	Дунд зэрэг	432
20	Сэлэнгэ	Баруунхараа	Дунд зэрэг	432
21	Төв аймаг	Мөнгөн морьт	Бага зэрэг	350
22	Төв	Баянчандмань	Бага зэрэг	223

Дээрх зураг, хүснэгтээс Монгол Улсын ойт бүс нутгийн зарим аймаг, сумдын хуурайшилтын индекс, түймрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон цэгүүдийг түүвэрлэж дүгнэлээ. *(Хуурайшилтын индекс нь газрын гадаргуугийн хуурайшилтыг тодорхойлох ач холбогдолтой бөгөөд энэ нь ой хээрийн түймрийн эрсдэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг).*

Ой, хээрийн түймэр тэр дундаа хил орчмын бүс нутаг дамнасан түймрийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд түүнтэй тэмцэх, хариу арга хэмжээний төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтад холбогдох талуудын оролцоо хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо маш чухал.

Тухайлбал ЦУОШГ нь байгалийн аюул гамшгийн үед богино, дунд болон

урт хугацааны өмнөөс сэрэмжлүүлэх, олон нийтэд мэдээлэх, сэрэмжлүүлэг хүргэх үүрэгтэй байгууллага юм. ЦУОШГ нь гамшгийн тухай сэрэмжлүүлгийг аймгууд дахь өөрийн харьяа газруудтайгаа хамтран хүргэх бөгөөд тэдгээр нь аймаг сумын удирдагуудад болзошгүй гамшигт үзэгдлийн тухай мэдээлдэг байна. Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын дагуу ЦУОШГ-аас ОБЕГ-Т хүргүүлсэн гамшгийн тухай сэрэмжлүүлэг мэдээг олон нийтэд тараана. Гамшигт үзэгдлийг урьдчилан тодорхойлохын тулд ЦУОШГ цаг уурын радарын систем ашиглаж байна. Энэхүү радарын систем нь бүхий л нутаг дэсгэрийг хамарч чадахгүй, зөвхөн Улаанбаатар хотын эргэн тойрны 200 км доторх үзэгдлийн урьдчилсан мэдээллийг өгөх боломжтой юм.

ДҮГНЭЛТ

Холбогдох хууль, тогтоомжид хийсэн шинжилгээний үр дүнд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа, холбоог зохицуулах эрх зүйн зохицуулалт хангалтгүй, хэрэгжиж буй заалтууд нь тодорхой бус байгаа нь хууль тогтоогчид, шийдвэр гаргагчдын хувьд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа, зохицуулалтын талаарх онол, арга зүйн ойлголт, мэдлэг дутмаг байгаатай холбоотой гэж үзлээ.

Мөн цаашид иргэн, аж ахуй нэгж байгууллагын алба хаагчдад ой хээрийн болон объектын түймрээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ, сургалт дадлагыг тогтмол зохион байгуулах, гадны улс орны сайш туршлагыг Монгол Улсад нутагшуулах нь зүйтэй бөгөөд дэлхий дахинд гал түймэр унтраах орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх иргэд олон нийтэд Онцгой байдлын байгууллагаас батлагдсан дүрэм журмыг мөрдүүлэх, гал түймрийн болон гамшгийн улсын хяналтыг чангатгах, иргэн аж ахуй нэгж байгууллагад тавигдах хариуцлагын тогтолцоог чангатгах шаардлага тулгарч байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг иргэний нисэхийн байгууллагатай хамтарч үйл ажиллагаагаа өргөжүүлэх, түймрийн эрсдэлтэй улиралд эргүүлийн нислэг үйлдүүлэх ажлыг ой, хээрийн бүс нутагт тогтмол зохион байгуулж ажиллах нь ой хээрийн болон объектын гал түймрийн өнөөгийн нөхцөл байдалд тулгамдаж буй асуудал болоод байгаа юм.

ЭХ СУРВАЛЖ

1. ОБЕГ, “Гамшгийн эрсдэлийн удирдлага” бүх шатны гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, гамшгаас хамгаалах албадын бүрэлдэхүүнд зориулсан гарын авлага, 2023 он, УБ хот
2. Игэний нисэх болон улсын нисэхийн дүрмүүд
3. амшгаас хамгаалах цагаан ном 2024 он
 4. Онцгой байдлын ерөнхий газар дэлгэрэнгүй статистик тоон мэдээлэл www.nema.gov.mn
 5. Сэлэнгэ аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, 2007 он
 6. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын баримт бичиг 2023 он /эмхэтгэл/